

Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл

Ажлын хэсгийн хуралдаан 2009 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 10 цагт Уул уурхайн үндэсний ассоциацийн хурлын танхимд эхлэв.

Ажлын хэсгийн хуралдаанд Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ажлын хэсгийн ахлагч Б.Эрдэнэсүрэн, ажлын хэсгийн гишүүд Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа, Ашигт малтмалын газрын тасгийн дарга Д.Бямбадагва, Сангийн яамны Нягтлан бодох, бүртгэлийн газрын дарга С. Мягмардаш, Багануур ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Дамбапэлжээ, Мэргэшсэн нягтлан бодогчдын институтын Удирдах зөвлөлийн гишүүн Л.Дондог, Монголын ажил олгогч эздийн холбооны гүйцэтгэх захирал Д.Жанцан, Миний монголын газар шороо хөдөлгөөний тэргүүн Б.Болдбаатар, Ил тод сангийн тэргүүн н.Цэрэнжав, Нээлттэй нийгэм форумын менежер Н.Дорждарь, Төлсөн авснаа нийтэл хөтөлбөрийн зохицуулагч Д.Сэнгэлмаа, Засгийн газрын ахлах референт Э.Сумъяа, Татварын ерөнхий газрын Татварын удирдлага хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Эрдэнэбаатар, Тусгай хэлтсийн дарга Я. Пүрвээ, Нүүрс ассоциацийн ажилтан Э.Сарангэрэл, Бороо гоулд компанийн санхүүч Ганхүлэг, Байгаль орчин аялал, жуулчлалын яамны мэргэжилтэн н.Гантөмөр нар оролцов. Мөн хуралдаанд ОУИТБС-ын ажлын албаны зохицуулагч Ш. Цолмон, санхүүгийн ажилтан Т. Хүрэлчимэг, Далай ван аудит компанийн захирал Ц.Жигдэн, Коффей интернэшнл компанийн зөвлөх Харрисон Митчелл, орчуулагч Д.Ганхуяг нар оролцов. Хуралд ажлын хэсгийн 25 гишүүн оролцох ёстой байсан боловч 14 гишүүн оролцож ирц 56 хувьтай байв.

Хэлэлцсэн асуудлууд:

1. ОУИТБС-ын баталгаажуулалтын урьдчилсан дүн /Коффей интернэшнл компанийн зөвлөх Харрисон Митчелл/

2. ОУИТБС-ын 2010 оны ажлын төлөвлөгөөний тухай /Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон /

Ажлын хэсгийн хуралдааныг Ажлын хэсгийн ахлагч Б.Эрдэнэсүрэн нээж хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулав.

Б.Эрдэнэсүрэн: Сайн байцгаана уу. Бид манай ОУИТБС-ыг баталгаажуулахаар шалгарсан Коффей интернэшнл компанийн урьдчилсан тайлантай танилцахаар энд цуглараад байна. Баталгаажуулагчид өөрсдийн тайлангаа та бүхэнд хүргүүлсэн байгаа. Ингээд танилцуулгаа эхэлье.

Коффей интернэшнл компанийн зөвлөх Харрисон Митчелл Монгол Улсын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгад баталгаажуулалт хийсэн талаархи урьдчилсан тайланг танилцуулав. /Тавьсан илтгэлийг хавсаргав. /Харрисон Митчелл: Та бүхнийг анхаарал тавьсанд баярлалаа. Одоо асууж тодруулах зүйл болон санал хүсэлт байна уу?

Ц.Жигдэн: Манай Далай ван аудитын компани нь энэ ажилд хамтран консорциум байгуулан оролцсон билээ. Бидний зүгээс энэ баталгаажилтын явцад хийсэн дүгнэлтүүдээ бас хэлье. Нэгдүгээрт, Эрнст энд Янгийн сүүлийн тайлан бол чанарын өндөр түвшинд хийгдсэн тайлан байсан. Тиймээс тайланг гаргах ажилд ахиц дэвшил гарч сайжирч байна гэж дүгнэсэн. Хоёрдугаарт, энэ ажлын албанд аудит хийлгэх ажлыг хариуцсан 1 ажилтан заавал байх хэрэгтэй юм байна гэж бодогдсон. Тайлантай холбоотой асуудлаар Засгийн газар, компаниуд болон аудитортой дагнан ажилладаг хүн байвал тайлан гаргах ажилд цаг хугацаа бага орж, чанарын хувьд сайжирна гэж бодож байна.

Н.Алгаа: ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд зориулсан тусгай хууль байхгүй байгаа нь хэрэгжилтэнд сөргөөр нөлөөлж байгаа гэжээ. Ийм хууль бусад оронд байдаг уу?

Харрисон Митчелл: Асуулт тавьсанд баярлалаа. Бусад улсад ОУИТБС-ын хуулиар зохицуулж байгаа практик байдаг. Жишээ нь, Нигери, Либери улсуудад ийм хууль байдаг. Хуулиндаа төрийн байгууллага ямар үүрэг рольтой оролцох вэ, тайлангаа гаргахгүй бол яах вэ гээд бүх зүйлээ ойлгомжтой болгосон байдаг.

Д.Жанцан: Хэрэгжүүлэгч орон гэж ер нь хэдэн улс байна вэ?

Харрисон Митчелл: Одоогоор Азербайжан, Либери гэсэн 2 улс л баталгаажилтандаа тэнцээд хэрэгжүүлэгчийн статусаа авчихсан байгаа. Монгол улс 3 дахь нь болох боломж байна. Харин ОУИТБС-ыг дэмждэг орон гэвэл 30 гаруй орон байгаа. Хэрэгжүүлэгч болчихлоо гээд ажил нь зогсонги болж болохгүй шүү. Улам сайжрах хэрэгтэй. Орон нутгийн түвшинд хэрэгжүүлэхийг улам идэвхжүүлэх шаардлагатай. Ер нь 3 гурван жилийн стратег боловсруулж мөрдөх хэрэгтэй байна. Санхүүгийн нэгдсэн тайлантай Санаачлагын тайланг сайн холбож өгөх нь чухал гэж үзэж байна. Одоогоор энэ байдал сул байгаагаас зөрүү гараад, дараа нь зөрүүг тодруулахад төвөгтэй байдалд оруулж байна.

Б.Эрдэнэсүрэн: Хэрэгжүүлэгч орон болсны давуу талууд юу байдаг вэ?

Харрисон Митчелл: Хамгийн гол ач холбогдол нь орлогын ил тод байдал хангагдана. Мөн олон улсын түвшинд баталгаажилт хийгдсэн гэдэг нь нэр хүндийн хувьд давуу талыг бий болгоно. Хэрэв баталгаажилтандаа тэнцэхгүй бол олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас эхлээд сөрөг хандлага үзүүлэх магадлалтай.

Н.Дорждарь: Шалгуур 5 дээр миний ойлгож байгаагаар олон улсын нарийн бичгийн дарга нарын газраас үнэлгээ өгөх ёстой гэж бодох юм. Давхар үнэлгээ өгөгдөөгүй биз? Шалгуур 13, 12-т Засгийн газар болон компаниуд ОУИТБС-ын тайланг ямар түвшинд гаргаж байгааг хянах боломж бага байна. Саяхан манай улсад Оюутолгой төслийн хөрөнгө оруулалтын гэрээг хийсэн байгаа. Та бүхэн энэ гэрээг олж үзэв үү?

Харрисон Митчелл: 5 шалгуурын хувьд бол бид өөрсдийн дүгнэлтийг Олон улсын нарийн бичгийн дарга нарын газар луу явуулсан бөгөөд тэд асууж тодруулах зүйлээ биднээс тодруулаад хамтарсан маягийн дүгнэлт гаргах юм. Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээг үзсэн. ОУИТБС-ын талаар заалт

оруулсныг талархан хүлээн авсан. Энэ нь дээд түвшиндээ ОУИТБС-ыг дэмжиж байгаагийн илрэл юм гэж ойлгосон.

Ц.Жигдэн: Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа бүх байгууллагууд олон улсын аудитын стандартыг баримтлах ёстой гэдэг ч зарим нь үүнийгээ барьдаггүйгээс болоод зөрүү гарч байгааг үгүйсгэхгүй ээ. Гэхдээ олборлох үйлдвэрлэлийн талаарх мэдээлэл энэ 4 тайланд бүгд тусгагдаж ил болж чадаж байна гэдэг бол маш том дэвшил юм. Зоригт сайд ч энэ талаар хэлсэн байдаг.

Н.Дорждарь: Нэг юм тодруулъя. Аудитлагдсан санхүүгийн тайлангийн дүнг ОУИТБС-ын тайлан дээр тавих ёстой. Энэ хэрэгжиж байна уу?

Ц.Жигдэн: Хуулийн дагуу 50 саяас дээш активтай байгууллагууд бүгд тайлангаа аудитаар оруулах ёстой. Энэ нь ч биелдэг.

Н.Дорждарь: Харин төрийн байгууллагууд яадаг юм бол?

С.Мягмардаш: Төрийн байгууллагууд бүгд Үндэсний аудитын газраар шалгуулдаг.

Харрисон Митчелл: Одоо 2008 оны тайланг нь авахдаа аудитлагдсан тайлангийн дүнг тавьсан гэж баталгаа гаргуулах хэрэгтэй. Саяын тайлан дээр бол Эрнст энд Янгынхан зарим маргаантай газрын анхан шатны баримтыг үзэж тулгасан байсан. Ер нь шаардлагатай бол анхан шатны баримтыг үзнэ гээд хуулиндаа оруулчих хэрэгтэй.

н.Цэрэнжав: Энэ урьдчилсан тайлан дээр Үндэсний зөвлөл муу ажилласан, ердөө 4 удаа хуралдсан гэжээ. Сая та нарын баталгаажилт хийгээд явсны дараа Үндэсний зөвлөл 2007 оны тайланг хэлэлцэж, хуралдсан байгаа. Энэ нь энэ тайланд тусгагдах уу?

Харрисон Митчелл: Бид Үндэсний зөвлөл хуралдсан талаар мэдээлэл авсан, мөн энэ тайландаа ч тусгасан. Гэхдээ хурал нь тогтмолжоогүй цөөхөн хуралдсан байдал ажиглагдаж байгаа тул энэ хэсгийг үлдээсэн юм. Хэрэв Ажлын хэсгийн гишүүд үүнийг хасах саналтай байгаа бол бид хасч болно.

Б.Эрдэнэсүрэн: Одоо асуулт дууссан бол саналаа хэлье. Бид энэ тайланг 2 дахь удаагаа хэлэлцэж байгаа. Бидний бодит байдлын сайн гаргаж өгсөн гэж үзэж байна. Хууль эрх зүй тодорхойгүй гэдэг бол яалт ч үгүй үнэн. Үүнийг тодорхой болгох хэрэгтэй. Үндэсний зөвлөлийн хурал цөөхөн хуралдаж байгаа. Жилд 4 удаа хуралдана гэж заасан ч 4 биш юмаа гэхэд 2 удаа хуралдахад болно гэж бодож байна. Сургалт, хурал дээр байгууллагуудаас 1 хүн ирчихээд дараа нь өөр хүн ирээд явдаг. Яг энэ асуудлаар дагнасан, мэргэшсэн хүнтэй байх ёстой дор бүрнээ анхаарах хэрэгтэй байна. Олон улсын төвшинд Монгол улсыг ОУИТБС-ыг хэрэгжүүлж байгааг, баталгаажилт хийгдсэн талаар сайн сурталчлах хэрэгтэй байна. Төрийн байгууллагуудын ОУИТБС-ын тоо мэдээтэй холбоотой хариуцлагыг дээшлүүлэх хэрэгтэй байна. За тэгээд баталгаажуулагчдын дэвшүүлсэн саналуудыг хүлээж авч байна. Баталгаажилтын тайланг үндэсний зөвлөлийн хуралд оруулах саналтай байна.

Шийдвэр: Энэ тайланг ойрын үед болох Үндэсний зөвлөлийн хуралдаанд танилцуулж батлуулахаар болов.

Б.Болдбаатар: Зөрүү гэдэг бол авилгал. Үүн дээрээ яаж ажиллах юм бэ?

Б.Эрдэнэсүрэн: Бид зөрүүг багасгах тал дээр их анхаарч ажилласан, 3, 4 удаа ажлын хэсэг хуралдсан бөгөөд анхны 23 тэрбумаас 10 тэрбум, 10 тэрбумаас 775 сая болтол буулгаж чадсан. Үндэсний зөвлөлөөс үлдсэн зөрүүний учрыг олно гэж мэдэгдсэн. Ер нь бол болохгүй гэхээсээ илүү болгох гээд л явж байгаа шүү дээ. За өөр санал хэлэх хүн байхгүй бол дараагийн асуудалдаа орёе.

Б.Эрдэнэсүрэн: 2008 оны нэгдсэн тайлангийн явц ямар байна вэ?

Ш.Цолмон: 2008 оны тайлангаа 113 компани ирүүлсэн, харин 184 компаниас татварын орлого хүлээн авсан тайланг Сангийн яамнаас ирүүлсэн байгаа. Харин тайланд аудит хийх компанийн хувьд урьдчилсан шалгаруулалтаас 4 компани шалгарч үлдсэн байгаа боловч нөхцөл байдал бидний сонгон шалгаруулах ажилд Эрнст энд Янг Монголиа Аудит ХХК-тай холбоотой асуудал үүсээд байна. Тус компанийг татвар төлөлттэй холбоотой асуудлаар Улсын мөрдөн байцаах газарт шалгагдаж байгаа гэж өдөр тутмын сонинд бичсэн, мөн аудитын эрхийг хураах талаар Монголын нягтлан бодогчдын институтээс Сангийн сайдад уламжилсан зэрэг байдал үүсчихээд байна. Бид Сангийн сайдын гаргах шийдвэрийг харж байна. Нөгөө талаас, Дэлхийн банкнаас шүүхээр буруутай нь тогтоогдоогүй байхад ямар нэг хууль бус үйлдэлд буруутгах, үнэлгээнээс хасахгүй байхыг зөвлөсөн. Энэ талаар ажлын хэсгийн гишүүдийн саналыг сонсмоор байна.

Л.Дондог: Эрнст энд Янг Монголиа аудит ХХК-тай холбоотой ноцтой байдал үүсчихээд байгаа нь үнэхээр үнэн юм. Монгол Улсад хэдэн тэрбумаар тооцогдох татварыг төлөөгүй, маргаан нь шүүх дээр явж байгаа тул энэ тендерт орох ер боломжгүй гэж бодож байна. Мөн НИММ аудитын түнш Нексиа гэдэг нь аудитын компаниудын сүлжээ юм байна. Нөгөө төлөөс, НИММ Зоос, Анод банкнуудыг аудитыг хийж байсан, гэтэл тэр 2 банк хоёулаа дампуурсан байгаа. Иймд найдваргүй аудитын байгууллагуудаас үнэлгээнээс хасах хэрэгтэй. Харин нөгөө 2 нь хэвийн үйл ажиллагаатай байгаа.

Д. Мягмардаш: Үнэхээр ийм асуудал Сангийн яаман дээр байгаа. Эрнст Янг 1 тэрбум төгрөгийн татвар төлөөгүй байгаа. Удахгүй асуудлыгн шийднэ гэж үзэж байгаа. Монгол компани ингэсэн бол аль хэдийнээ хассан байгаа, гэтэл гадаадын компани гээд, Дэлхийн банк тэгэсэн, ингэсэн ингээд хамгаалаад байх зүйлгүй шүү.

Д.Дамбапэлжээ: Тайлангийн хандив гэдгийн тухайд хэлэхэд компани яг мөнгөн дүнгээр өгсөнийгөө л хандив гэмээр байгаа юм. Янз бүрийн наадам энэ тэр зохион байгуулчихаад тэрийгээ худлаа өндөр дүнгээр бичээд байгааг болимоор байна.

Н.Алгаа: Говь-Алтай аймагт хайгуулын тусгай зөвшөөрөлтэй компани бүрээс 2 сая төгрөг, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй компани бүрээс 5 сая төгрөг аймагт хандивлах тухай шийдвэр гаргаж, хэрэв өгөхгүй бол үйл ажиллагааг нь

зогсооно гэж аймгийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн Хурал нь компаниудыг дарамтлаад байгааг ер нь юу гэж ойлгож болох вэ?

Д. Жанцан: Компаниуд ч яах вэ тайлангаа гаргаж байгаа юм байж, төрийн байгууллагын ил тод байдлыг хангаж ажилламаар байна.

Шийдвэр: Үнэлгээний хороо ажлын хэсгээс гаргасан саналыг анхаарч үзээд үнэлгээний ажлаа түргэвчлэх.

Б.Эрдэнэсүрэн: 2010 оны төлөвлөгөөгөө хэлэлцье. Ш. Цолмон төлөвлөгөөг танилцуулна.

Ажлын албаны зохицуулагч Ш. Цолмон 2010 оны төлөвлөгөөг танилцуулав (Төлөвлөгөөний төслийг хавсаргав).

Б.Эрдэнэсүрэн: Энэ 2007 оны тайланг 10 сард гаргана гэсэн байна. Энэ чинь ийм хойшоо байдаг нь юу билээ?

Ш.Цолмон: Энэ алдаа гарчээ. 1 дүгээр сард юм шүү. Засья.

Д. Мягмардаш: Төлөвлөгөөнд байгаа бүүх сургалтанд Сангийн яамны төлөөлөлийг оруулж өгөх хэрэгтэй байна.

Б.Эрдэнэсүрэн: Маягтуудыг өөрчлөх санал солилцох талаар хийх ажлыг оруулъя. Компани болон Засгийн газартай сайн ярья. Хариуцлагын тогтолцоог сайжруулах хэрэгтэй байна. Мөн ОУИТБС-ын талаар УИХ-ын гишүүдэд мэдээлэл хүргэж, таниулах хэрэгтэй байна. Баярцогт сайд Үндэсний зөвлөлийн хурал дээр Засаг дарга нарын үр дүнгийн гэрээнд энэ ОУИТБС-ын ажлыг хийх үүрэгтэй гээд оруулна гэж хэлснийг ажил хэрэг болгох хэрэгтэй байна. Сургалтыг төрийн байгууллага болон компаниудын ОУИТБС-ыг хариуцсан албан тушаалтнуудад хийвэл үр дүнтэй гэдгийг дахин хэлье. За тэгээд төлөвлөгөөгөө батлах уу?

Бүгд: Батлая.

Н.Дорждарь: Би бас нэг юм хэлээдэхье. Манай ОУИТБС-ын 2009 оны санхүүгийн асуудал шийдэгдээгүй байгаа. Баярцогт сайд улсын төсөвт суулгая гэж хэлсэн байсан. Өөр нэг нэмэлт мэдээлэл өгөхөд ОУИТБС-ыг дэмжиж Япон улс хандив өгөхөөр болж байгаа юм билээ. Тэгэхээр Японы Засгийн газарт бас хандаж бичиг явуулах ажлыг зохион байгуулж болох юм байна гэж бодогдсон.

Б.Эрдэнэсүрэн: Энэ их зүйтэй асуудал байна. Тэгээд ажлын хэсгийн гишүүд өөрсдөө бас үйл ажиллагаагаа сурталчлах хэрэгтэй. Сүүлийн үед хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай идэвхтэй хамтарч ажиллаж байна. Хэвлэлийн бага хурал хийлгэлээ, ярилцлагууд өглөө.

Ж.Болдбаатар: Бид нарт ажлын хэсгийн гишүүн гэсэн үнэмлэх өгч болдоггүй юм болов уу. Энд тэнд явж байхад заавал бичиг баримтаа үзүүлж байж мэдээлэл авах хэрэгтэй болоод байна.

Б.Эрдэнэсүрэн: Тэр болох байх. Ажлын албаныхан үнэмлэх өгөх талаар хөөцөлдөөрэй.

Ажлын хэсгийн хурал 12 цаг 00 минутад дуусав.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:


Ерөнхий сайдын ахлах зөвлөх,
Ажлын хэсгийн ахлагч



Б.Эрдэнэсүрэн

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын албаны санхүүгийн ажилтан



Т.Хүрэлчимэг